



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/288

Булган сум

Эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, 66 дугаар зүйлийн 66.1, Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.9, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны хуралдааны XIX/08 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтын 1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган сумын орон нутгийн чанартай авто замын засвар, арчлалтад 50,000,000 (тавин сая) төгрөгийг захиран зарцуулах эрхийг Булган сумын Засаг дарга (П.Нөхөрлөлбаяр)-д олгосугай.

2.Авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтад зарцуулах эрх олгогдсон хөрөнгийг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулж, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, тайлагнахыг Булган сумын Засаг дарга (П.Нөхөрлөлбаяр)-д үүрэг болгосугай.

3.Дээрх ажлын хөрөнгийг аймгийн авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээнд батлагдсан "Орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжийн засвар" зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (О.Сайнзаяа)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

